



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/23

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Ховд аймгийн Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулиудын ширээ сандлыг шинэчлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дарга: Ц.Даваасамбуу - Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн

Гишүүдэд: Б.Нямдорж - Боловсрол, соёл, урлагийн газрын төсөв, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн

Б.Дуламсүрэн - Төрийн бус байгууллагын төлөөлөл
Г.Бямбадорж - Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн дарга: Х.Дэмид - Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /Ц.Даваасамбуу/-нд даалгасугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Х.Дэмид /-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.ЭНХБОЛД

